



НИЙСЛЭЛИЙН АГААРЫН ЧАНАРЫН АЛБАНЫ ДАРГЫН ТУШААЛ

2015 оны 05 сарын 10 өдөр


Дугаар 4/05

Улаанбаатар хот


Г Ажлын хэсэг байгуулах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, “Төсвийн тухай” хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 16.5.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус албанаас Дорноговь аймгийн Даланжаргалан суманд байрлах “Монголын алт МАК” ХХК-ийн коксон шахмал түлшний үйлдвэр болон Зүүн баян суман дахь “Дэрст тохой” ХХК-ийн антерцитийн үйлдвэрийн нөхцөл байдал, тоног төхөөрөмжийн хүчин чадал, бүтээгдэхүүний чанар байдлыг үзэж, танилцах шаардлагатай болсон тул ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.
2. Тухайн ажлыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж, үр дүнг 2015 оны 05 дугаар сарын 25-ны дотор албаны даргад танилцуулахыг ажлын хэсэг /Г.Даваажаргал/-т даалгасугай.
3. Ажлын хэсгийн томилолтын зардал болох 1 460 000 /нэг сая дөрвөн зуун жаран мянга/ төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг нягтлан бодогч /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА 
Ч.БАТСАЙХАН

Нийслэлийн Агаарын чанарын албаны
даргын 2015 оны 05 дугаар сарын // ны
өдрийн тушаалын хавсралт.



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮНИЙ НЭРС

Д/д	Овог нэр	Албан тушаал
1	Х.Галымбек	Дэд дарга
2	Ч.Сэдэд	Бүлэглэсэн дулаан хангамжийн системийн халаалтын зуух хариуцсан мэргэжилтэн
3	Г.Даваажаргал	Суурин эх үүсвэрийн хэмжилт хариуцсан мэргэжилтэн
4	С.Батсая	Техник хариуцсан мэргэжилтэн
5	М.Отгонбаяр	Орчны хэмжилт хариуцсан мэргэжилтэн
6	О.Түвшинжаргал	Гэр хорооллын дулаан хангамж мэргэжилтэн
7	А.Мөнхгэрэл	Хүний нөөц, тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн
8	Б.Баясгалан	Хий, шингэрүүлсэн хийн технологи хариуцсан мэргэжилтэн
9	Д.Санчирбаяр	Гэр хорооллын дулаан хангамж хариуцсан мэргэжилтэн
10	Н.Насанжаргал	Сэргээгдэх эрчим хүч хариуцсан мэргэжилтэн
11	Х.Гэрэлчuluун	Суурин эх үүсвэрийн хэмжилт хариуцсан мэргэжилтэн
12	Д.Гантуяа	Дотоод болон шуурхай ажил хариуцсан мэргэжилтэн
13	О.Алтангэрэл	Хөдөлгөөнт эх үүсвэрийн хэмжилт хариуцсан мэргэжилтэн
14	Ч.Өлзийбат	Оператор жолооч
15	Ж.Батбаатар	Оператор жолооч

НИЙСЛЭЛИЙН АГААРЫН ЧАНАРЫН АЛБА